

МОНГОЛЧУУДЫН ХҮН ТӨВТ ХЭМЖЭЭС

А.Пүрэвжанцан

Түлхүүр үг: *тэргүүн, алд, дэлэм, тохой, төө, сөөм, хуруу, ямх*

Хүн төрөлхтний түүхэнд гарсан мэдлэг ухааны нэг бол хэмжээ илэрхийлэх арга, хэмжих ёс мөн. Нүүдэлчин монголчуудын давтагдашгүй нэгэн зүйл бол ертөнцийн юмс үзэгдлийг жишин харьцуулах их бага, том жижиг, урт богино, хүнд хөнгөн, цаг хугацаа, орон зайг илэрхийлэх хэмжээсүүд тоймгүй олон билээ.

Төв Азийн өндөрлөгт орших монголчуудын хувьд жилийн дөрвөн улиралтай, улирал бүр нь өөр өөрийн ааш араншинтай, цаг агаарын эрс тэс уур амьсгалтай, Алтай, Хангай тал хээр, говь цөлийг хосолсон өргөн уудам нутаг газартай, уламжлалт нүүдлийн сонгодог мал аж ахуй эрхэлдэг, тэнгэр шүтлэг, бөө мөргөл, бурхны шашин шүтдэг зэргээс хамааран хэмжээ илэрхийлэх арга, хэмжих уламжлал, сэтгэхүй сэтгэлгээ нь нэн өвөрмөц хэв шинжийг хадгалсаар өнөөг хүрчээ. Монголчуудын хэмжээс биендээ байдаг гэж ярилцдаг. Эдгээрээс бид зөвхөн монгол хүний биеэр жишин илэрхийлэх хүн төвт хэмжээсүүдийг толгой хэмээх тэргүүн эрхтнээс эхлээд хөлийн ул хүртэл дүйцүүлэх утгатай нь тодорхой жишээ баримтаар тоймлон танилцуулж байна. Үүнд, толгойтой үснээс их, ам нээх зуур, цээж дүүрэн, тэвэр, тэвэр дүүрэн, бөгс өндийх зуур, бөгс эргэх зайгүй, борви бохисхийлгүй зэрэг хэмжээсүүдийн дүйх утгыг харилцан хамааралтай олон зүйлээс шалтгаалан тодорхойлон оноох боломжгүй учраас илтгэх утгатай нь харьцуулан (их бага, том жижиг, олон цөөн, удаан хурдан) гэх мэт ерөнхийлөн тоймлож илэрхийлэхээс өөр аргагүй юм. Тодруулбал, шинжлэх ухаан баримт, нотолгоог шаарддаг хэдий ч бөгс эргэх зайгүй гэх хэмжээст хэллэгийн дүйцэх утгыг оноон тайлбарлах гэвээс миний, таны бөгс хэдүй зайнд эргэж, ямар хэмжээтэй болох нь их л инээдтэй хэрэг болох буй за. Үүнийг үл өгүүлэн доорхи жишээгээр үзүүлэхдээ энд илэрхийлсэн тоон утгыг 170-180 см өндөртэй хүнээр багцаалан харгуулсан болно. Үүнд:

1. Толгойтой үснээс их (маш их) Жишээ нь:

“Цаг нар, зав зайгүй их ажил *толгойтой үснээс их* байна” (Пүрэвжанцан, 2017)

2. Нүд ирмэх зуур, хар нүд хамхих хооронд, ам нээх зуур, алга урвуулах хооронд, бөгс өндийх зуур (1-2 сек орчим) гэх хэмжээсүүд аливаа зүйлийн үргэлжлэх цаг хугацааны маш хурдан түргэнийг илэрхийлж байгаа юм. Жишээ нь:

“Урьд ноос үс, арьс ширхэн юу өгсөн бүхнийг голж шилэлгүй авдаг нугас загас шиг уян зөөлөн ааштай данжаадуудыг ингэж *алга урвуулахын хооронд* зүс араншингаа хувиргах юм гэж хэн мэдлээ.” (Эрдэнэ, 1986:49).

3. Хүзүүгээр татах (150-180 см), цээжээр татах (130-140 см), мөрөөр татах (145-150 см), улаан сугаар татах (130-140 см), суугаа хүний суган доогуур (70-80 см), босоо хүний борвин доогуур (50-60 см), босоо хүний дайтай (170-180 см), бүсэлхийгээр татах (70-80 см), өгзгөөр татах (60-70 см), өвдгөөр татах (40-50 см), шагайгаар татах (10-15 см) гэсэн илэрхийллүүд нүүдэлчин монголчуудын цаг агаар, байгаль дэлхийнхээ ааш аягийг танин мэдсэн гайхамшигт тандалт болж, усны гүн, өвсний өндөр, цасны зузаан, ер нь аливаа зүйлийн өндрийг жишиж буй хэмжигдэхүүн юм. Жишээ нь:

“Хөвчийн өвдгөөр татсан цасан дундуур хол хол алхсан нэгэн хүний мөр тэртээд цайвалзах хүүрэг татсан өндөр уулын ар ташланд сүүдэртэн харлах балар их хөвчийг чиглэн оджээ.” (Догмид, 2015:218)

4. Алд (үзүүр алд 180 см орчим), (мухар алд 170 см), дэлэм (үзүүр дэлэм 120 см), (мухар дэлэм 110 см), сөөм (үзүүр сөөм 15 см), (мухар сөөм 10 см), төө (үзүүр төө 20 см), (мухар төө 15 см) гэх нь аливаа юмны урт богино, их багыг эргэцүүлэн хэмжиж байна. Жишээ нь:

Ахыгаа алд хүндэл

Дүүгээ дэлэм хүндэл (Зүйр цэцэн үг)

5. Алга дарам (10 см), эрхий дарам (2 см), бөгс эргэх зайгүй (бага) гэвэл аливаа зүйлийн орон зай, байр талбайн уйтган явцууг илэрхийлж байна. Жишээ нь:

“Монголын газар шороог Манж, Хятадуудад алдвал хүн байтугай үхсэн хүний яс ч үл амарна. Данжила чи нүдээ хөдөлж байсан цагт харийн хар элэгтэнд алга дарам газар ч бүү өг. Ухаарав уу. Алга дарам газар ч...” (Догмид, 2010:79)

6. Алгын чинээ, атгын чинээ, чигчийн чинээ (1-2 см), хуруунчинээ (1 хуруу 2 см), (2 хуруу 4 см), (3 хуруу 6 см), (4 хуруу 8 см), (5 хуруу 10 см), эрхийн чинээ (2-3 см), хумсын чинээ (1 см), хар хумсын чинээ (2 мм), тохойн чинээ (үзүүр тохой 40-45 см), (мухар тохой 35-40 см), ямх (2-3 см) гэсэн хэмжээсүүдээр аливаа зүйлийн урт богиныг жишин хэлэлцдэг. Жишээ нь:

Алгын чинээ газраас нь

Атгын чинээ шар тос олдож гэнэ. (Батжаргал, 2011:4)

7. Балга (5-10 гр), үмх (5-10 гр), чимх (0,1-0,2 гр) аливаа зүйлийн хүнд хөнгөн, өчүүхэн жаахныг илэрхийлжээ. Жишээ нь:

“Билгүүн номч Б.Ринчен гуайд нэгэн эрхэм орос хэлийг нэлээд гадарладаг боллоо гэж онгиргон зан гаргажээ. Хариуд нь өвгөн эрдэмтэн ”Гадарлах ч нэг хэрэг, доторлодог бол мөн сайнсан. Үмх мах, чимх давс гээд гадарладаг хэлээрээ хэл дээ” хэмээн гартаасан гэдэг” (Галсан, 2016: 43)

8. Алхам: нэг алхам (70 см), хоёр алхам (140), гишгэм: цуваа (60 см), зэрэгцээ (20 см) хэмээн ихэвчлэн газрын баримжааг хэмждэг ажгуу. Жишээ нь:

“Боорчи хормойгоо өндөр сөхөн их алхдалаар Жононгийн барьсан цацарт орж ирвэй.” (Инжаннаш)

Дүгнэлт

Монголчуудын дээрх биеэр хэмжээ илэрхийлэх үгс нь үндэсний хэв шинжийг хадгалсан, суурьшмал болон хагас суурьшмал соёл иргэншилтэй ард түмний хувьд нэн их онцлогтой байдаг. Гэвч монгол хэлний үгийн сангийн тодорхой хувийг эзэлдэг хэмжээ илэрхийлэх үг, түүний хувьсал өөрчлөлт, бүтэх арга зэргийг тухайлан судалсан нь нэн ховор байгаа юм. Мөн монголчуудын хэл, сэтгэлгээний онцлогийг илэрхийлэх уламжлалт ахуй соёлтой холбоотой

үг хэллэгийг судлах нь монгол хэлний үгийн сангийн бүрдэл, түүний хувьсал хөгжил хийгээд үгтг а үүрэг, хэрэглээний өөрчлөлт зэргийг тодруулахад чухал ач холбогдолтой болно.

Нөгөө талаар, асар их хурдацтайгаар хөгжин дэвшиж даяаршин буй өнөө үед өдөр тутмын хэмжээ илэрхийлэх үг хэллэгийг хэрхэн харгуулах, уламжлалт ёс, арга ухаантай холбон тайлбарлах эсэх нь ч ихээхэн анхаарал тагдаг.

Summary

Upper mentioned human-based measurement stating words are still has its own uniqueness for people with semi nomadic lifestyle and culture. But study on measurement describing words, which covers specific percentage in word hoard of Mongolian language, their evolution, method of creation are extremely rare. Moreover study on Mongolian language, on words describing uniqueness of Mongolian traditional culture and lifestyle are significant for determining of word hoard structure of Mongolian language, its evolution, development, meaning.

On the other hand, at thisage of rapid development and globalization, questions such as how to compare regular measurement stating words, should we define them by connecting them to traditions and methods are attracts attention

Номзүй

Батжаргал Д. Долоон бор оготно. Уб., 2011.

Галсан Т. Аугаа шогч Ринчений аянган егөө үгс. Уб., 2016.

Догмид Б. Босоо ороолон. Уб., 2015.

Догмид Б. Бурхны шувуу. Уб., 2010.

Инжаннаш В. Их асар.

Пүрэвжанцан А. Монголчуудын хэмжээ илэрхийлэл. Уб., 2017.

Эрдэнэ С. Занабазар. Уб., 1986.

1. Тийлэгтэй үгсүүд нь хэлний үндэсний бүрэлдэхүүнд гол үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тэдгээрийг судлах нь хэлний бүрэлдэхүүнийг ойлгоход чухал ач холбогдолтой болно.
2. Нил үгсүүд нь хэлний үндэсний бүрэлдэхүүнд гол үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тэдгээрийг судлах нь хэлний бүрэлдэхүүнийг ойлгоход чухал ач холбогдолтой болно.